

МОНГОЛД УЛС ТӨРИЙН ХЭЛМЭГДҮҮЛЭЛТ ЭХЭЛСЭН ЦАГ ХУГАЦААНЫ ТУХАЙД

Тайжууд Х.МӨНХБАЯР

Товч утга: Хорьдугаар зууны Монголын түүхийн ээдрээт асуудал болох улс төрийн хэлмэгдүүлэлтийн түүхийг судлаачид шинжилсээр байгаа боловч уг үйл явц хэзээ, хэрхэн эхэлсэн талаар нягтлан үзээгүй байна. Тиймээс эл бэсрэг судалгаагаар Монголд улс төрийн хэлмэгдүүлэлт эхэлсэн цаг хугацааг тодруулахыг хичээсэн болно.

Түлхүүр үг: Улс төрийн хэлмэгдүүлэлт, хүний эрх, түүх бичлэг, эрүү шүүлт, цааз, Бодоо, Тогтох тайж, Цэвээн тэргүүн, Саж лам, оросууд, Ардын Засгийн газар

Оршил

Улс төрийн болон үндэс угсаа, эдийн засгийн зэрэг олон шалтгаанаар нийгмийн гишүүдээ хэлмэгдүүлэх, хохироох үзэгдэл дэлхийн түүхэнд тохиолдсоор иржээ. Тиймээс хэлмэгдүүлэлтийг улс төрийн хэлмэгдүүлэлт, эдийн засгийн хэлмэгдүүлэлт гэсэн хэд хэдэн хэлбэрт зааглан үзэж болох ч эдгээр нь дангаараа оршдоггүй, нэг нь нөгөөгөө нөхцөлдүүлдэг ажээ. XX зуунд өргөн хүрээтэйгээр илэрч, олон улсыг хамарсан улс төрийн хэлмэгдүүлэлтийг¹ эдийн засгийн хэлмэгдүүлэлт дагалдаж байв.

XX зууны монголын марксистүүх бичлэг улс төрийн талаар хэлмэгдэгсдийг “Хувьсгалын эсэргүү” гэдэг ойлголтын хүрээнд тодорхойлж байснаас бодит үнэнийг судлан тогтоох асуудал орхигдсон билээ. Харин 1990 оны ардчилсан өөрчлөлт шинэчлэлтийн хүрээнд түүхийг бодитоор нээн гаргахад чиглэсэн өргөн далайцтай ажил өрнөсний үрээр Монгол дахь улс төрийн хэлмэгдүүлэлтэд холбогдох зарим зүйл тодрон гарсан юм.

Гэхдээ 1920, 30-аад оны Монголын улс төрийн түүх, улс төрчдийн намтрыг судлах дашрамд тус оронд өрнөсөн улс төрийн хэлмэгдүүлэлтийн асуудлыг тоймлон хөндөж байсан учир түүх бичлэгт уг үйл явцын эхлэлийг нарийвчлан үзсэнгүй аж. Сэдэвт холбогдох хүрээн дэх түүх бичлэгийг бүлэглэн үзэхэд,

Нэгдүгээрт, Монгол дахь улс төрийн хэлмэгдүүлэлт 1922 оны намар Бодоо нарыг буудан хороосноор эхэлсэн гэх хандлага давамгайлж байна. Тухайлбал, Ерөнхий сайд Бодоогийн талаар судалгаа хийсэн эрдэмтэн Лха.Бат-Очир бүтээлүүддээ, “1922 онд Бодоо нарыг улс төрийн хилс хэрэгт цаазалснаар Монголд

¹ Фашистын Герман улс хүмүүсийг үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхах үзлийг хөөрөгдөж, еврей нарыг үндэстний хувьд хавчин мөрдөж, алж устгаж байсан бол ЗХУ тэргүүтэй социалист тогтолцооны хүрээнд өрнөсөн улс төрийн хэлмэгдүүлэлтийн уршгаар гэм зэмгүй олон арван сая хүн хэлмэгдэж хохирчээ. *Улс төрийн хэлмэгдэгсдийн намтрын товчоон*, Боть XVIII, УТХХСТөв, УБ, 2013, 11.

ул төрийн хэлмэгдүүлэлт эхэлсэн” гэдэг санаа дурдсаныг² судлаачид дэмжсэнээр 1998 онд батлагдсан “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай” хуульд энэхүү хандлага тусч, энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д Хуулийн үйлчлэх хүрээг,

“Энэ хууль 1922 оноос эхлэн “БНМАУ-ын шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах журмын тухай хууль” хүчин төгөлдөр болсон өдөр хүртэлх хугацаанд Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнд хамаарна³”

хэмээн заасан байдаг.

Хоёрдугаарт, улс төрийн зүтгэлтний намтрыг судлахдаа улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэнийг нь зөвхөн тухайн хувь хүнд хамаарах хүрээнд нягталж байснаас Монголд улс төрийн хэлмэгдүүлэлт эхэлсэн асуудлыг цогц байдлаар тодруулах бололцоогүй байв.

Тийнхүү монголын түүх бичлэгийн хүрээнд, Монголд улс төрийн хэлмэгдүүлэлт төдийд эхэлсэн гэж заасан зүйл үгүй боловч Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлсэн “Монгол Улсын түүх” бүтээлд,

“Төр, намын удирдлагын төвшинд буй болсон улс төрийн амьдралыг ээдрээтэй болгохуйц зөрчил зөрөлдөөний явцад 1921 оны хувьсгалын зүтгэлтнүүд өвөр хоорондоо маргалдан тэмцэж, нэг нэгийгээ эрсдүүлэн хэлмэгдүүлж байв. Эл үйл явдлын эхнийх нь Д.Бодоо, С.Данзан нарын хоорондын маргаан байв. Хувьсгалын дараа хэмжээт цаазат засаг тогтоох тухай нэг саналтай байсан боловч агуулгын талаарх зөрөөтэй ойлголт нь тэднийг зөрчилдүүлж, энэ нь улс орон, намын дотоод амьдрал, нам эвлэлийн хоорондын харьцаа зэрэг асуудлууд дээр хурцаар илэрч, эцэстээ 1922 оны эхээр Д.Бодоог бүх албан тушаалаас нь чөлөөлж, VI сард баривчлан, VIII сарын 30⁴-нд «ардын засгийг устгах» хэмээсэн хилс хэрэгт холбогдуулан амь насыг нь хохироов. Түүнтэй хамт ардын намыг анх

² Бат-Очир Л. *Бодоо сайд: Үзэл ба үйлс*. УБ, 1991; Анхны долоогийн нэг, Намын амьдрал, №7, УБ, 1989, 69-79; Бодоо сайд хэн байв. “*Засгийн Газрын мэдээ*, №09 (22), 1992.; *Буруугүй буруутнууд*, Зуун мод, 1993, 4-13; Ерөнхий Сайд Бодоод хятадын харгис генерал Жан-Зо-Линтэй холбоо тогтоосон, Автономит Засгийг сэргээх гэсэн хэмээн ял тулгажээ. “*Улаанбаатар таймс*” №75 (559), 2001; *Догсомын Бодоо*, Хэлсэн, бичсэн зүйлийн түүвэр, УБ, 2001; *Догсомын Бодоо* (Д.Бодоогийн амьдрал үйл ажиллагааны талаар доктор, профессор Л.Бат-Очирын хийсэн судалгааны бүтээлийн эмхэтгэл ба Д.Бодоогийн бүтээлээс) УБ, 2010.

³ <http://www.legalinfo.mn/law/details/510?lawid=510> (Хууль зүйн яамны харьяа Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: Хандалтын огноо: 2014.09.10)

⁴ Эл бүтээлд Д.Бодоо нарыг цаазалсан өдрийг 1922 оны 8 дугаар сарын 30 хэмээн ташаарчээ.

үүсгэлцэж, хувьсгалын хэрэгт зүтгэж явсан Д. Чагдаржав, Ө. Дэндэв, да лам
Пунцагдорж, гүн Тогтох нарын 14 хүнийг шийтгэн хэлмэгдүүлжээ⁵”

хэмээн тэмдэглэснээр Бодоо нарыг 1922 онд хэлмэгдүүлсэн нь тус орон дахь улс төрийн хэлмэгдүүлэлтийн эхний тохиолдол байсан гэх үзэл санаа албан ёсоор батжин тогтоход хүргэсэн юм.

Гэвч энэ нь бүрэн бус нотолгоонд тулгуурласнаас гадна иргэнийг улс төрийн шалтгаанаар шийтгэн, амь биеийг нь хохироосон явдал буюу хүний эрхийн зөрчил төгссөн цагтагч холбогдол өгч, хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн буюу хязгаарлагдсан цаг хугацааг авч үзээгүй нь учир дутагдалтай болсон. Онцлоход, Бодоо нарыг цаазалсан явдалд биш, харин уг хэрэгт хэлмэгдэгсдийн эрх, эрх чөлөөг хэзээ ямар шалтгаанаар зөрчсөн бэ гэдгийг, тухайлахад, гэрийн хорионд оруулсан, баривчилсан, эд хөрөнгийг хураасан буюу битүүмжилсэн, эрх хэмжээг нь ямар нэгэн байдлаар хаан боогдуулсан явдалд анхаарал хандуулах нь улс төрийн хэлмэгдүүлэлтийн эхлэл, түүнд хамаарах цаг хугацааг тодруулахад дөхөм үзүүлнэ.

Тиймээс судлаач миний бие Монголд улс төрийн хэлмэгдүүлэлт эхэлсэн цаг хугацааны тухайд дүн шинжилгээ хийхийг хичээлээ.

Монголд улс төрийн хэлмэгдүүлэлтийн эхэлсэн асуудлыг авч үзэхэд түүхэн үйл явдал, үзэгдлээс гадна хүний эрх зөрчигдсөн байдлыг анхаарах нь ач холбогдолтой юм. Чингэж үзэх хэд хэдэн үндэслэл байгааг хэлэх хэрэгтэй. Үүнд, нэгдүгээрт, улс төрийн хэлмэгдүүлэлтийн илрэл бүр хүний эрхийн зөрчлийг агуулдаг тул хүний эрх, эрх чөлөөнд улс төрийн шалтгаанаар, хууль зүйн бодот үндэслэл, нотолгоо баримтгүйгээр халдсан, хязгаарласан үйлдэл хийсэн хугацааг улс төрийн хэлмэгдүүлэлт эхэлсэн цэг гэж үзэх эрх зүйн үндэслэл бий. Хоёрдугаарт, 1996 онд «Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалын өдөр» болгон хуульчилснаар жил бүр хэлмэгдэгсдийг бүх нийтээрээ дурсч, хүндэтгэл үзүүлж буй 9 дүгээр сарын 10-ны өдөр бол Монгол дахь улс төрийн хэлмэгдүүлэлтийн оргил үеийн эхлэл юм. 1937 оны энэ өдөр нийтийг хамарсан их баривчилгаа эхэлж, тус улсын иргэдийн эрх зөрчигдсөн. Тиймээс улс төрийн хэлмэгдүүлэлтийн эхлэл авч үзэхдээ иргэний эрх, эрх чөлөөг улс төрийн шалтгаанаар зөрчсөн, хөндсөн байдлыг харгалзах шаардлагатай байна.

Иймд юуны өмнө, эдүгээгийн түүх бичлэгт Монгол дахь улс төрийн хэлмэгдүүлэлтийн эхлэл болгон үзэж байгаа 1922 оны 8 дугаар сарын 31-ний өдөр Бодоотой хамт цаазлуулсан 15 хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн байдлыг нягтлах замаар Монголд улс төрийн хэлмэгдүүлэлт хэзээ эхэлсэн бэ хэмээх асуултын хариуг олж болох талтай.

Баримтаас үзэхэд, тэдгээр хүмүүсээс Сангийн яамны сайд байсан Г. Лувсанцэвээний эрх, эрх чөлөөнд хамгийн түрүүнд халдаж, 1921 оны 7 дугаар

⁵ Монгол Улсын түүх (Тавдугаар боть), ШУА-ийн Түүхийн хүрээлэн. УБ, 2003, 146.

сарын 20-нд баривчилжээ. Энэ нь Монгол дахь улс төрийн хэлмэгдүүлэлт 1921 оны 7 дугаар сард эхэлсэн байж болохыг харуулдаг.

1. Монголд улс төрийн хэлмэгдүүлэлт эхэлсэн цаг хугацааг мөшгөх нь

Үүнийг тодруулахын тулд Г.Лувсанцэвээнийг баривчлах үеийн Монголын нөхцөл байдал, түүнийг юуны учир баривчилсныг нягтлан үзэх нь зүйн хэрэг.

1921 оны 7 дугаар сарын 6-8-нд ЗОУ, АДБНУ-ын Аялан байлдах корпус хийгээд Ардын журамт цэргийн хамтарсан хүчин Нийслэл Хүрээнд орж ирээд⁶ тус хотыг хяналтдаа авч, цэрэг байлдааны өрнийн уламжлалыг баримтлан нийслэлд Комендатын⁷ газрыг байгуулсан нь иргэний эрхийг улс төрийн шалтгаанаар хөсөрдүүлэх нэгэн нөхцөл болжээ.

Учир нь, эл Комендантын газар⁸ хотын дотор дэг журам сахиулах цэргийн цагдаагийн үүргийг гүйцэтгэхийн дашрамд сөрөг хүчний үлдэгдлүүдийг илрүүлэн устгах ажил явуулж байв. Эрдэмтэн Д.Гомбосүрэнгийн судалгаа⁹ болон архивын баримтаас тэрхүү Комендатын газрын үйл ажиллагааг мэдэж болно.

Монгол Ардын Засгийн хэргийг Түр захиран шийтгэх газрын тэргүүлэгчдийн 1921 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хурлаар, цагаантнуудын сууж байсан хашаа байшинг битүүмжлэн сахих зэрэг ажлыг хариуцах тушаалтанд Эрдэнэдорж (МАХЦ-ийн Штабын дарга П.И.Литвинцев)-ийг томилж, комендант гүн Жигмэддоржтой хавсран ажиллах үүрэг өгчээ.¹⁰

Үүнээс нэг хоногийн дараа 7 дугаар сарын 8-нд Нийслэл Хүрээний хот харгалзах бүх цэргийг захирах В.В.Писарев, цэргийн комиссар Ф.Белов нарын тушаал гарч, Нийслэл Хүрээний комендантын албыг зохион байгуулж, даргаар нь И.Б.Вокнуаевыг томилсон байна.¹¹

Монгол Ардын Засгийн хэргийг Түр захиран шийтгэх газрын тэргүүлэгчдийн 1921 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хурлын 8 дугаар зүйлд, “Монголын намын цэрэг ба Орос Зөвлөлт Засгийн цэрэг нар нэгдэн Хүрээг эзлэн авсан тул цагаан намын хэмээн хаана явавч даруй дайчлан бариулахаар Цэргийн

⁶ Мөн дээрх, 129.

⁷ Комендант (монгол дуудлагаар “хаминдаа” гэх нь ч буй)- “Хот бэхлэлтийн цэргийг захирагч”, “эрхлэгч” гэсэн хоёр утгатай орос үг. Дамдинсүрэн Ц. Лувсандэндэв А. *Орос-Монгол толь бичиг (Русско-Монгольский словарь)*, УБ, 1983, 221. Уг сурвалж нь, цэргийн захирагч, дарга гэсэн албан тушаалтныг илэрхийлэх “commandant” хэмээх франц үг болно Гомбосүрэн Д. Нийслэл Хүрээний цэргийн комендант ба Комендантын газрын үйл ажиллагаа (1921 оны долоодугаар сар), *Тусгаар тогтнол*, №2, УБ, 2012, 73.

⁸ Комендантын газар (Комендатура). Цэргийн гарнизон [хүрээ], цайз, бэхлэлт, станц, портын Цэргийн удирдлагын байгууллага. Үүнийг хуучин цагийн монголчууд “Комендантын яам” хэмээж байсан.

⁹ Гомбосүрэн Д. *Нийслэл Хүрээний цэргийн комендант ба Комендантын газрын үйл ажиллагаа* (1921 оны долоодугаар сар), *Тусгаар тогтнол*, №2, УБ, 2012, 73-78.

¹⁰ Мөн дээрх 73.

¹¹ Мөн дээрх.

яамнаас харьяат олон газар зарлан тушааж, орос, буриад цэргийг Ардын засгийн газар хүргэн ирүүлээд Зөвлөлт Засгийн Газар ба Алс Дорнод газрын засгийн хэрэг эрхлэгчид лугаа хамтад нийлж байцаан шийтгэхэд гүйцэтгүүлье¹²” хэмээн заасан нь Орос Комендантын газрын үйл ажиллагааг цагаантны үлдэгдлүүдийг илрүүлэхэд чиглүүлсэн эрхийн акт болжээ.

Тэр дагууд цагаантны талын хэмээн сэжиглэгдсэн хүмүүсийг баривчилж эхэлсэн бөгөөд Олнаа өргөгдсөний 11 дүгээр оны 6 сарын 3 буюу аргын 1921 оны 7 дугаар 8-нд Ардын Түр Засгийн Газрын Комендантын яамнаас орос, буриад 30 гаруй хүнийг баривчлан Шүүх яаманд хүргэн өгч, гянданд хориулсан¹³ бол энэ тоо дөрөвхөн хоногийн дараа 123-д хүрчээ. Тэднийг бароны цэрэг, Баяр гүнгийн цэрэгт явсан хийгээд цагаантанд тусалсан гэх үндэслэлээр буруутгаж байв. Баригдагсад нь угсаатны олон бүлгийн төлөөлөл: халх, цахар, буриадууд болон орос, хятад, япон, солонгосчууд аж¹⁴.

Баривчилгааг Өргөө хотын комендант, Монголын цэргийн хороо, Оросын цэргийн тагнуулын дарга, Улаан армийн Сретений 12 дугаар бригад, жанжин Д. Сүхбаатар нараас удирдан явуулсны дотор монголчууд болон хятадуудыг барих ажиллагааг Сүхбаатар толгойлон гүйцэтгэжээ¹⁵. Монголчуудын дунд Жамц бэйл, Дорж гүн зэрэг хэргэмтэй ноёдоос гадна Ховдын цагаантнуудад 10 тэмээ цай буулгачихаад буцаж явахдаа 1921 оны 7 дугаар сарын 25-нд замаасаа Комендантын газар баригдсан 23 настай ард Гомбонооров зэрэг хүмүүс ч байлаа¹⁶.

Баривчлагдагсдын дотроос орос, буриадуудыг Зөвлөлтийн талд шилжүүлэн өгч байв. Тухайлбал, барон Унгерны албаны хүн буриад Доржбазаровыг гэртээ агуулан эмчлүүлж байсан хэргийн учир Хүрээнд сууж байсан буриад Данзанбазаров (20 настай)-ыг 1921 оны 7 дугаар сарын 11-ний шөнө орос морин цэрэг 3, нэг буриадтай ирж Доржбазаровын хамт барьж Комендантын газар хүргүүлсний¹⁷ зэрэгцээ тус газарт баригдаж гянданд суусан буриад Данзанбазар, Цэрэнцэдэнов, Санжайсимдамба, Цэрэндондов-Сэрээтэр, Дорж-Эрдэнэ, Дамдин, Дорж-Гомбожав, Пунцагчоймбол, Доржбазар нарын 9 хүнийг цагаан намын Унгерны цэрэгт явж, оросын Эрхэм их цэргийн өмнөөс байлдсан гэж Орос улсын их цэргийн ноёдын тусгайлан шийтгэж захирах газарт шилжүүлж, түүгээр шийтгэн дуусгахыг Монголын тал 1921 оны 7 дугаар сарын 17-нд мэдэгдэж¹⁸ байжээ.

Нийслэл хүрээнд явагдаж байсан тэрхүү баривчилгаа, байцаан шийтгэх ажиллагаа нь нэгдсэн зохион байгуулалтгүй дурын шинжтэй, замбараагүй байсан тул Ардын Засгийн Газрын Шүүх Таслах Яам энэ байдлыг засах шат дараалсан арга хэмжээ авсан байна. Үүнд, юуны өмнө Олнаа өргөгдсөний 11 дүгээр он

¹² Мөн дээрх, 75.

¹³ Монгол улсын Үндэсний Төв Архив (МУУТА), Х-284, Д-1, ХН-21, 1, 2.

¹⁴ МУУТА, Х-284, Д-1, ХН-21.

¹⁵ Мөн дээрх, 4-10.

¹⁶ МУУТА, Х-284, Д-1, ХН-7, 162.

¹⁷ Мөн дээрх, 153.

¹⁸ МУУТА, Х-284, Д-1, ХН-5, 3.

7 сарын шинийн 1 (1921.08.04)-нд түшмэл гаргаж, гянданд хориулсан хэрэгтэн хүмүүсийн нэр хошууг тодорхойлон дансалсан төдийгүй үүнээс хойш тус яаманд шийтгэгдэх хүмүүсийг нэмэн хорьсон аваас нэр, хошуу ба хэргийн учрыг тодорхойлон ирүүлэхээс гадна дахин хэрэгтэн хүмүүсийг дураар барьж гянданаа хориулах тухай бүр тус яамнаа мэдэгдэж байхыг 1921 оны 8 дугаар сарын 4-нд Комендантын газар хуудсаар явуулсан бичигт анхааруулжээ¹⁹. Улмаар Цагдан сэргийлэх Хорооноос байцаан барьсан хэрэгтнийг Шүүх Таслах яамны ялтан хорих гянданд хорьж, орос дарга цэргүүд харгалзаж байсны дээр хэрэгтнийг нааш цааш хүргэхэд эрх биш зэвсэгтэй цэрэг хэрэгтэй тул харьяат гяндангийн хуяг 16 хүнийг нь цэрэг болгож, зэвсэг олгуулах саналыг 1921 оны 8 дугаар сарын 8-нд гаргажээ²⁰. Тэгэхэд Шүүх яамны гяндан (Комедант хавсарсан Цагдан сэргийлэх газрын Гянданг захирах түшмэл)-гийн даргаар орос хэл, бичигтэй буриад Базар Содовпов ажиллаж байв²¹. Тэрчлэн ялтан дэмсгөх тэмдэгт хувцас, таних тэмдэг тус тус 20-ыг үйлдэж ирүүлэхийг Сангийн яамнаас 1921 оны 8 дугаар сарын 10-нд хүсчээ.²²

Цагаан намын орос барон Унгернтэй холбоо харилцаатай байсан гэх үндэслэлээр тэр үед баривчлагдсан монголчуудын доторх нөлөөтэй хүмүүсийн тоондөнөөх Лувсанцэвээн ван орж байлаа. Барон Унгерн гэ мин цэргийг Нийслэл Хүрээнээс хөөн зайлуулсны дараа Олнаа өргөгдсөний 11 дүгээр он цагаан сарын 15 (1921.02.22²³)-нд таван яам дахин байгуулагдаж, Богд хааны зарлигаар хишиг хүртээхэд төр улсаа сэргээх хэрэгт идэвхийлж манлайлсан барон Унгерны монгол цэргийн жанжин, Сангийн яамны сайд, тэргүүн зэрэг тайж Лувсанцэвээнд чин вангийн хэргэм, шар хүрэм, хүрэн жолоо, Бат ерөөлт жанжин цол шагнасан²⁴ ажгуу.

Өргөөгийн шоронгийн захиргаанаас 1921 оны 7 дугаар сарын 26²⁵, 9 дүгээр сарын 3-нд²⁶ тус тус гаргасан хоригдогсдын жагсаалтад Лувсанцэвээнийг 7 дугаар сарын 20-нд хотын комендант барьсан гэж дурдсаныг шоронгийн дарга Хамбаевын гарын үсэгтэй 1921 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн дээрх бүртгэлийн 36-рт, “Лубейнца²⁷ ван, монгол гүн, 7 дугаар сарын 20-нд хотын комендант барьсан²⁸” гэж бичсэн тэмдэглэл гэрчилдэг.

Түүнчлэн, Шүүх яамны сайд Магсаржав, дэд сайд Тогтох нараас Богд хаанд айлтгасан нэгэн айлтгалд, “манай Монгол Ардын засгийн газраас муу хулгай Барон лугаа сүлбээлэн хэрэг өдөх явдалд сэрдсэн ван Лувсанцэвээний биеийг

¹⁹ Мөн дээрх, 13.

²⁰ Мөн дээрх, 286.

²¹ Мөн дээрх, 72.

²² Мөн дээрх, 16.

²³ Сономдагва Ц. *Он тооллын хэлхээ \1912-1930\, Түүхийн судлал*, Tomus VII, Fasc 13, УБ, 1968, 226.

²⁴ Магсаржав Н. *Монгол Улсын шинэ түүх*, Эмхтгэж хэвлэлд бэлтгэсэн Эмгэнт О. Батсайхан, Харнууд 3. Лонжид, УБ, 2010, 224, 225.

²⁵ МУУТА, Х-284, Д-1, ХН-7, 144.

²⁶ МУУТА, Х-284, Д-1, ХН 8, 39-42.

²⁷ Лувсанцэвээн гэдгийг оросууд тийнхүү хазгай бичжээ.

²⁸ МУУТА, Х-284, Д-1, ХН-7, 144.

барилж, байцаан шүүн шийтгүүлээр шавь боолчуудын яаманд тушаасан²⁹” гэж тодорхойлсон нь Цэвээн тэргүүнийг 1921 оны 7 дугаар сарын 20-нд Засгийн газрын шийдвэрээр Нийслэл Хүрээний Комендантын газраас баривчилсан нь зайлбаргүй аж. Тэр цагт эл Комендантын газрыг оросын талынхан эрхлэн хариуцаж байсныг бодоход баривчилгааг орос цэрэг гүйцэтгэсэн нь тодорхой.

Цэвээн тэргүүнийг барон Унгернтэй холбогдуулан чингэж баривчласнаар барахгүй Ардын Засгийн газрын таван яамнаас тус тусын түшмэлийг томилон оруулсан³⁰, Шүүх яамны дэдсайд Тогтох ахлахтай Тусгай комисс улс төрийн хэрэгт мөрдөн байцаажээ³¹.

Ван Лувсанцэвээнд Ардын засгийг устгахыг оролдож, Их зуугийн чуулганы Ордосын Отог бэйлийн хошууны хэмээх лам Шаддовжамбаар³², “Жамбал ван³³ Лувсанцэвээн надад буу зэвсэг өгсөнгүй гэнэт оргон явав. Одоо Лувсанцэвээн би гагцаар яах билээ. Барон та хэдий хэр олон цэрэгтэй байна” хэмээх үгийг барон Унгернд уламжлан хэлүүлж, амрыг эрэн хадаг бариулаад, “Лувсанцэвээнийг тэндээ хэвээр суусугай. Хэрхэх аргагүй болж” гэсэн хариуг авчруулсан гэдэг ял тулгасан байна³⁴.

Улмаар Шүүх Таслах яамнаас ял төлөвлөн Олноо өргөгдсөний 11 дүгээр он 8 сарын 11 (1921.09.12)-нд Богд хаанд айлтгасанд, хаантан уг айлтгалд засвар оруулж, ялыг хөнгөвчлөөд:

“Барон Унгерн энэ завсар нэгэнт баригдсан хэмээх тул Лувсанцэвээний биеийг түүний өөрийн гэрт түр харгалзуулан сахиул. Бусдыг гуйсан ёсоор болгогтун”

хэмээн зарлиг буулгасан тул Лувсанцэвээний биеийг гэрт буцааж, Цэргийн яамнаас тусгайлан цэрэг гаргаж, цаг түвшрэх хүртэл харгалзуулсан ба Шаддавжамбын бие 85 хоног гянданд хорьж цээрлэл үзүүлсэн тул үлэх ялд харгуулж, биеийн албан зүтгүүлэхээр Цэргийн Яаманд шилжүүлэн хүргүүлсэнээр³⁵ Богд хаантны ачаар Лувсанцэвээн түр зуур гэрийн хорионд суух шийтгэл хүлээж, амь мэнд үлджээ.

Цэвээн тэргүүнийг шийтгэсэн нь үнэндээ эрх зүйн үндэслэлгүй байсан

²⁹ МУУТА, Х-284, Д-1, ХН 24, 82-90.

³⁰ МУУТА, Х-284, Д-1, ХН-24, 68-75; МАНБТ. Х-12, Д-1, ХН-22, 53-57.

³¹ МУУТА, Х-284, Д-1, ХН- 24, 24-26.

³² Ордосын харьяат лам Шаддовжамба хэмээх энэ хүний тухай мэдээ хомс ажээ.

³³ Жамбал ван хэмээх нь буриад Жигмиджав Жамбалон болно. Нийслэл Хүрээг гэгч мингээс чөлөөлөхөд гавьяа байгуулсан тул Богд хааны зарлигаар түүнд чин вангийн хэргэм, хүрэн жолоо, чин зүтгэлт жанжин цол шагнасан. Унгерн их цэргээ авч хөдлөхөд Жамбалон Нийслэл Хүрээг сахин хамгаалах хэргийг эрхлэн үлдсэн. Ардын Журамт цэрэг болон улаан оросын нэгдсэн хүчин Нийслэл Хүрээнд орж ирэхийн өмнөхөн амиа аргацаан зүүн зүгт зайлан одсон боловч удалгүй Дарьганын цэргийн хороонд бууж өгөөд Нийслэл Хүрээнд хүргэгдэх зам зууртаа өртөөний мориор зугадаад цэргийн суманд өртөж алуулжээ Магсаржав Н. *Монгол Улсын шинэ түүх*, Эмхтгэж хэвлэлд бэлтгэсэн Эмгэнт О.Батсайхан, Харнууд З.Лонжид, УБ, 2010, 225, 249, 266.

³⁴ МУУТА, Х-284, Д-1, ХН-24, 82-90; Х-284, Д-1, ХН-1, 48.

³⁵ МУУТА, Х-4, Д-1, ХН-10, 182-186.

гэлтэй. Учир нь Лувсанцэвээнээс Унгернд элчин зарсан нь Олноо өргөгдсөний 11 дүгээр он 5 сарын 30 (1921.07.05)-ны өдрийн явдал учир Хэмжээт эрхт засгийг тунхаглахаас даруй 5, 6 өдрийн өмнөх Монголын төв Засгийн газрын Сангийн сайдын хувьд холбогдох энэ асуудлыг 1921 оны 7 дугаар сарын 11-ний өдрөөс албан ёсоор босч баталгаажсан Ардын Засгийн газар шүүн хэлэлцэх нөхцөлгүй байсан мэт.

Цэвээн тэргүүнийг 1921 оны 7 дугаар сарын 20-нд тийнхүү улс төрийн хэрэгт баривчилснаас Монголд улс төрийн хэлмэгдүүлэлт эхэлсэн цаг хугацааг тооцох саналыг миний бие өмнө нь илэрхийлж байсан³⁶ боловч сүүлийн үедилэрсэн зарим баримтууд энэ саналаа хянан үзэхэд хүргэж байна.

Өргөө (Нийслэл Хүрээ)-гийн шоронгийн захиргаанаас 1921 оны 7 дугаар сарын 26³⁷, 9 дүгээр сарын 3-нд³⁸ тус тус гаргасан хоригдогсдын жагсаалтад Цэвээн тэргүүнээс гадна Монголын нэгэн эрхэм хүн бүртгэгдсэн нь Горлосын Тогтох тайж байлаа. Дээрх бүртгэлүүдэд Тогтох тайжийг 7 дугаар сарын 19-нд Хотын комендант барьсан гэж тэмдэглэснээс үзэхэд Орос комендантын газар Тогтох тайжийн эрх, эрх чөлөөг хязгаарласан нь Цэвээн тэргүүнээс ч өмнөх цагт холбогдох тул Тогтох тайжийн явдлыг анхаарах шаардлагатайгаас гадна уг хэрэг улс төрийн шалтгаантай байсан эсэхийг тодруулах нь чухал юм.

Ардын засаг мандсны дараахан Нийслэл хүрээний Эрдэнэ шанзодба, Да лам, Далай бламын Зүүн сангийн мэдээчин, Их шавийн харьяат гэвхүй Равдан, гэлэн Тогоо, эхнэр Хандан, Нийслэл Хүрээний хойт замын гуравдугаар өртөөнд албан хааж суусан Сэцэн хан аймгийн чуулганы дарга Эрдэнэ далай ван Наваанцэрэнгийн хошууны гэлэн Жүнэй нарын олон этгээд Тогтох тайжид холбогдуулан, бэйс Тогтох, түүний тушаалаар явсан цахар цэргүүдэд 1920 оны өвлөөс хойш удаа дараа дайчлагдан булаагдсан өөр өөрийн харьяатсан, аймаг орон, жас, хувьсын сүү, шар тос, эд, мал зүйлийг эгүүлэн олгуулах, бэйс Тогтоход хүүтэй зээлүүлсэн бие мөнгө, төгрөг, орос цаасны зэргийг эх хүүгийн хамтаар бүрэн төлүүлэх, бэйс Тогтохынхоос Их сангийн хураагдсан юмыг хөсөгний хамтаар авчруулахаар мөн сангаас очсон түлхүүрч, лам Мөрдэндэв нарт тэдгээр юмыг бэйс Тогтох эс өгсөн учир Эрдэнэ шанзодбын яамнаас Их сангийн хураагдсан юмыг өөр тэргэдийн хамт өгмү хэмээн зарагдаж очсон зайсан лам Лувсанбалдан, түшмэл зайсан Баваасан нарт бэйс Тогтох тэдгээр юмыг эгүүлэн өгөхгүй харин харьяат цэргүүдийг жагсааж муу сүрийг үзүүлэн “Та нарыг буудан алмуй” гэх төдийгүй, Дээдийг холбогдуулан,

³⁶ Мөнхбаяр Х. Улс төрийн хэлмэгдүүлэлтийн үйл явц дахь Монголын тагнуулын байгууллагын оролцоо. *Аюулгүйн манаанд 90 жил сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл*, УБ, 2012; Мөнхбаяр Х. “Группийн хэрэг” ба Лхүмбийн байцаалт, эрүү шүүлтийн тухай нягтлах нь, *Лхүмбэ-110 жил эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл*, УБ, 2012; Мөнхбаяр Х. Цэвээн тэргүүнээс Чимидийн Энхээ хүртэл, Өнөөдөр сонин, 2012.09.25.

³⁷ МУУТА, СХ-284, Д-1, ХН-7, 144.

³⁸ МУУТА, СХ-284, Д-1, ХН-8, 39-42.

“Богдын дэргэдулаан жинс зүүж, Зарлиг лүндэн хэмээн хүнийг айлган явдаг луйварчин нар байдаг. Та хоёр тэр буй за. Одоо та нарыг зүй нь шууд алаад Шанзодбын яаманд мэдэгдвээс зохих асан. Нэгэн удаа түдгэлзье. Дахин ирбээс алмой. Манай бичээч нар эд нарын нэрийг бичиж автугай. Би өгөх боловч өөрөө Богдтай уулзаж байж өгөхөөс бус, та хоёр мууд хэрхэвч өгөхгүй. Таны Богдыг гэ мингийн гарт ороод амь мэгдэж байхад би цэргээ явуулж, хүчин хавсран амийг авалцсан нь ийм өшөө болох буюу. Тийм сайн юм болбоос юунд гэ мингийн гарт орсон буй. Хэрэв намайг ийнхүү хэлэв хэмээбээс Та нар явчихсан гэ миндээ хэлж алуулсугай. Гэ мингийн юмыг олон хүн авахад Та нар юм олж авч чадсангүй бөгөөд таны Богд дагалдсан шанзодба та нар миний авсан юмнаас дам луйвардах хэмээж ирэв үү”

хэмээх зэргээр зүй бус үг хэлсэн зэрэг хэргийг мэдүүлжээ.

Түүнчлэн энэ үед Монгол Ардын Төв Хороо, Орос комендантын газар Тогтохын нэр дээр гомдол гаргасан³⁹ байх боловч тэрбээр уг газруудыг хэрхэн хохироосон нь тодорхой бус байна.

Эцэст Шүүх яам олон газрын гомдлыг хянаад Нийслэл Хүрээний Цагдан сэргийлэх хороонд тушаал өгч Тогтох тайжийг гэр бүлийн зарим гишүүд болон холбогдогсдын хамт баривчлуулжээ⁴⁰.

Тогтох тайжийн хэргийг 3 сар орчим хянан шалгасны эцэст, Олноо өргөгдсөний 11 дүгээр он 9 сарын шинийн 5 (1921.10.06)-нд хуралдсан Засгийн газрын 18 дугаар хурлын 15 дугаар зүйлд, цагийн самуунаар далимдаж бусдын юмыг дураар дайчилж ашиглан явсан бэйс Тогтохын хэргэмийг эвдэж, сул хүмүүн болгон нэг жилийн үйлтгэх ял оноохоор төлөвлөсөн нугалбарын эхийг баталсныг⁴¹ маргааш нь хаанд айлтгасанд уг нугалбарт Богд хаан улаан бийрээр, “Зарлиг мэдэв” хэмээн цохсон тул Тогтохын үйлтгэх (хөдөлмөрлөх-Х.М) ялыг түүгээр үйлтгүүлэн шийтгүүлэхээр түүний биеийг Цэргийн яаманд тушааж хуудас дагуулан Цэргийн яаманд хүргүүлжээ⁴².

Тэрчлэн, “Олноо өргөгдсөний 11 дүгээр он (1921 он)-д гянданд хоригдогсдын бүртгэл” хэмээх нэгэн баримтанд,

“№6. Бэйс Тогтох 58 настай, Их шавийн харьяат, Комендантын газраас хүргэн ирсэн. Бусдад дутсан өрийг сүрээр завшсан хэрэгт 11 оны 6 сарын 15 (1921.07.19)-нд гянданд хоригдсон. 11 оны 9 сарын 7 (1921.10.08)-нд нэг жил үйлтгэх ял оноож, Цэргийн яаманд шилжүүлсэн⁴³”

³⁹ Гомбосүрэн Д. *Зоригт баатар Э.Тогтох*, УБ, 2003.

⁴⁰ МУУТА. Х-284, Д-1, ХН-24, 82-90; Гомбосүрэн Д. *Нийслэл Хүрээний цэргийн комендант ба Комендантын газрын үйл ажиллагаа* (1921 оны долоодугаар сар), *Тусгаар тогтнол*, №2, УБ, 2012, 76.

⁴¹ Монгол Ардын Намын Баримтын Төв (МАНБТ) Х-12, Д-1, ХН-23, 30.

⁴² МУУТА. Х-4, Д-1, ХН-10, 268-272.

⁴³ МУУТА. Х-284, Д-1, ХН-36.

гэж бичсэн зэргээс үзэхэд Тогтох тайжид үйлтгэх буюу албадан хөдөлмөрлөх нэг жилийн ял оноож, ял шийтгэлийг Цэргийн яамны хяналтад хүлээлгэхээр болсон нь тодорхой байна.

Тийнхүү Тогтох тайжийг Цэвээн тэргүүнээс 1 хоногийн өмнө 1921 оны 7 дугаар сарын 19-нд баривчилж, таслан шийтгэсэн боловч үүнээс даруй арваад хоногийн урьд түүнийг орос цэргүүд баривчилж, цагдан хорьсон баримт буйг лавшруулан нягтлах шаардлагатай юм.

Партизан Нанзад дуртгалдаа Тогтохыг баривчлахад биеэр оролцсон тухайд,

“Ардын журамт цэрэг Нийслэл хүрээг эзэлсний маргааш өглөө нь Тогтох тайжийг барьж авахаар зуун улаан цэргийн хамт тэдний хашааг бүслэн, би хоёр нөхрийн хамтаар ороход Тогтох тайж өмнөөс гарч ирэхэд нь баривчлан биед байгаа маузер бууг хураан тэдний нэрийн дор явсан цэргүүдэд нэгжлэг хийж, бага сага зэвсгийг хураан авсан юм⁴⁴”

гэжээ. Монгол Ардын Засгийн хэргийг Түр захиран шийтгэх газрын тэргүүлэгчдийн 1921 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хурлаас, цагаантны талд алба хааж агсдыг баривчлах шийдвэр гаргасан, 7 дугаар сарын 8-нд Нийслэл Хүрээний Орос комендантын албыг байгуулж, баривчилгаа явуулж эхэлснийг бодолцоход, Тогтох тайжийг Нийслэл Хүрээг эзэлсний маргааш өдөр нь Зөвлөлтийн 100 цэргийн хүчээр баривчилсан гэдэг мэдээнд итгэж найдах бүрэн үндэстэй юм.

Харин Ардын Журамт цэрэг 1921 оны 7 дугаар сарын 6-нд Нийслэл хүрээнд орж ирснийг харгалзахад Нийслэл хүрээг эзэлсний маргааш нь 1921 оны 7 дугаар сарын 7 болох тул тэр өдөр Тогтох тайжийг анхлан баривчилсан бололтой. Чингэж Ардын түр Засгийн газрын шийдвэрээр цагаантантай холбоотой байсан хүмүүсийг барих үеэр Тогтох тайж баривчлагджээ⁴⁵. Тогтох тайж биедээ зэвсэг агуулж байсан, 32 ширхэг винтов бууг Найданжаваар дамжуулан барон Унгернд өгсөн, түүний харьяат Баяр гүн, Жамц бэйл, Найданжав ван нар цэргийн хамт цагаантны талд орсон⁴⁶, хүү Нэймэнгийн гэрээс 2 винтов, 50 сум олдсон явдлыг түүнийг баривчлах шалтаг болгожээ⁴⁷.

Түүнээс хоёр хоногийн хойно Богдыг Хэмжээт эрхт хаанд өргөмжлөн, Ардын засагт улсыг тунхагласан 7 дугаар сарын 11-ний баярт өдөр тохиоход Ардын Засгийн газрын Ерөнхий сайд Бодоо, Ардын Намын дарга Данзан, Засгийн хэрэг эрхлэх газрын дарга Батхаан нарын гарын үсэгтэй 74 тоот тусгай үнэмлэхийг Тогтох тайжид олгож⁴⁸, сулласан байна⁴⁹.

⁴⁴ Монгол Ардын журамт цэргийн дуртгалууд, Боть II, УБ, 1986, 379-385.

⁴⁵ Гомбосүрэн Д. *Зоригт баатар Э.Тогтох*, УБ, 2003, 40, 45.

⁴⁶ Гомбосүрэн Д. Нийслэл Хүрээний цэргийн комендант ба Комендантын газрын үйл ажиллагаа (1921 оны долоодугаар сар), *Тусгаар тогтнол*, №2, УБ, 2012, 77.

⁴⁷ Гомбосүрэн Д. *Зоригт баатар Э.Тогтох*, УБ, 2003, 45.

⁴⁸ Мөн дээрх, 40.

⁴⁹ Гомбосүрэн Д. *Нийслэл Хүрээний цэргийн комендант ба Комендантын газрын үйл ажиллагаа*

Орос хэл дээр бичигдсэн уг үнэмлэхний агуулгыг эрдэмтэн Д.Гомбосүрэн аругайн дараах мэт орчуулсанаас үзэхэд, Тогтох тайж Ардын Засгийн газрыг хүлээн зөвшөөрсөн, улмаар зэвсгээ хураалгасан, тиймээс Ардын засгийн газрын ивгээлд орсон аж.

Хүснэгт 1. Тогтох тайжид олгосон үнэмлэх⁵⁰

	Үнэмлэх
Монгол Улсын Ардын Хувьсгалт Түр Засгийн Газар	Тогтох бэйс бол Монгол Улсын Ардын Хувьсгалт Түр Засгийн Газрыг хүлээн зөвшөөрөөд зэвсгээ хураалган эдүгээ Ардын хувьсгалт Засгийн Газрын ивгээлд байгаа тул үүнийг Засгийн Газрын зөвшөөрөлгүйгээр нэгжлэг хийхийг хориглоно.
1921 оны долдугаар сарын 11-ний өдөр	Засгийн Газрын дарга Бодоо
№74	Намын Төв Хорооны дарга Данзан Засгийн хэрэг эрхлэх эрхлэгч Батхаан

Энэ нь Тогтох тайж Ардын засгийн газрыг зөвшөөрөхгүй байсан буюу зөвшөөрөх эсэх нь тодорхой бус байсан учир баривчилсныг харуулж байгаа мэт боловч үнэн хэрэг дээрээ түүнийг баривчлахад монголчууд бус оросууд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэснийг анхаарбал дээрхээс өөр байдал анзаарагдана.

Мэдээж хэрэг улс орон үймээн самуунтай байсан учраас зэвсэг нуусан гэдэг нь цэргийн хүнийг буруутгах ноцтой явдал бус, аян шалтаг төдий зүйл байсан нь тодорхой юм. Тэгэхлээр, улс төрийн байр суурийн хувьд хэзээнээс Монголоо туурга тусгаар улс болгон, гаднаас хараат бусаар байлгахын төлөө эрмэлзэн тэмцэж явсан үндэсний үзэлтэн байсан нь Тогтох тайжийг удаа дараалан баривчлах, олон зүйлийн хэрэгт буруутган яллах нөхцөл болжээ гэж хэлэхэд хүргэж байна.

Хүний эрхэнд улс төрийн ашиг сонирхлоор халдсан, эрх, эрх чөлөөг нь хууль бусаар хязгаарласан төрийн үйлдэл өөрөө улс төрийн хэлмэгдүүлэлт мөн тул Тогтох тайжийг тийнхүү улс төрийн шалтгаанаар баривчилж, хорьж цагдсан явдлыг улс төрийн хэлмэгдүүлэлт байсан гэж үзэх бүрэн үндэстэй.

Тогтох тайжийг Ардын засгийг тунхагласан баярт өдөр 1921 оны 7 дугаар сарын 11-нд суллаад төд удалгүй мөн сарын 19-нд баривчилж, эрүүгийн хэрэгт шийтгэсэн нь оросуудын шахалттай холбоотой болов уу. Үүнийг Лувсанцэвээнд холбогдох нэгэн баримтын агуулгаас анзаарч болно. Шүүх яамны тэргүүн сайд, бэйл Магсаржав, дэд сайд, гүн Тогтох нараас Богдхаандайлтгахаар бэлтгэж байсан, магадгүй айлтгаад буцаагдсан ч байж болох айлтгалын нэгэн төсөлд:

(1921 оны долоодугаар сар), *Тусгаар тогтнол*, №2, УБ, 2012, 77.

⁵⁰ Мөн дээрх.

“Лувсанцэвээн гавъяа бүхүй боловч ял даанч хүнд болсны дээр хөнгөнөөр авчихадуг хэргийн учир гадаадаас тусалсан төлөөний түшмэд нарын санаанд үл нийлэлцэх зэрэг харштай зүйл үлэмж бүхүй⁵¹”

хэмээсэн байдаг.

Тогтоход холбогдох дээрх хэргүүдээс үзэхэд Монголд улс төрийн хэлмэгдүүлэлт эхэлсэн цаг хугацаа нь МАН-ын зэвсэгт хүчин Нийслэл Хүрээнд орж ирсний маргааш 1921 оны 7 дугаар сарын 7-ны өдөр ажээ.

2. “Саж ламын хэрэг” гэгч дэгдсэн цаг хугацаа

Цэвээн тэргүүнтэй хамт “Бодоогийн хэрэг”-т шийтгүүлсэн, Бодоод үл хамаарах өөр нэг хүн бол Төвөдийн харьяат, “Саж лам” хэмээгч Жамъянданзан юм. Унгерн Нийслэл Хүрээг эзлэхийн урьдбуриад Тубановаар удирдуулсан тусгай отряд илгээж, хятад цэргийн хяналт дор Өвлийн ордондоо гэрийн хорионд байсан Богд хаан, Улсын эх Дагина хоёрыг 1921 оны 2 дугаар сарын 2-нд чөлөөлөхөд Саж ламын магнайлан төвөд аравт чухал үүрэг гүйцэтгэсэн⁵² нь Жамъянданзанг монголчуудын дунд “Саж лам” гэдэг нэрээр алдаршуулсан.

Гэвч 1921 оны намар түүнийг улс төрийн хэрэгт холбогдуулан баривчилсан байна. Саж ламыг баривчилсан цаг хугацааг манай түүх бичлэгт янз бүрээр тэмдэглэжээ. ЗХУ-ын Шинжлэх Ухааны академи, БНМАУ-ын Шинжлэх Ухааны академийн хамтын бүтээл гэсэн тодорхойлолтойгоор 1955, 1966, 1984 онуудад хэвлэгдсэн “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх” бүтээлд:

“Хар шар феодалууд, хуучин хаант засгаа сэргээн байгуулах гэж ард түмний эсрэг хуйвалдааныг удаа дараагаар хийж байв. Тэд, Богдын шадар хүн, Унгерний түвд цэргийг даргалж байсан саж лам (Жамъянданзан)-ын толгойлсон түвд лам нар ба мөнгө хүүлэгчдийн тусламжтайгаар хувьсгалын эсэргүү үймээн зохион байгуулахыг оролдож үзлээ.

Үймээн гаргагчид 1921 оны 12 дугаар сарын 21-ний өглөө, Засгийн газрын байшинг дайрах гэж байгаад мөн 12 дугаар сарын 20-ны шөнө үүнд оролцсон 48 хүн ардын цэргийн байлдагчдад баривчлагдсан юм⁵³” гэж бичиж байсан бол манай улсын Шинжлэх Ухааны академиас дагнан гаргасан төрийн албан ёсны түүх болох 1969 онд хэвлэгдсэн “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх” бүтээлд:

“1921 оны 12-р сард Саж ламын хуйвалдааныг илрүүлж, түүнд оролцсон 48 хүнийг баривчилжээ. Баривчлагдсан хүмүүст Ардын засгийн газар энэрэнгүй хандаж байсныг Богд гэгээн ашиглаж шийтгэлийг зөөлрүүлсэн ба заримыг

⁵¹ МУУТА. Х-284, Д-1, ХН-24, 82-90; Х-284, Д-1, ХН-1, 48.

⁵² Кузьмин С.Л. *Барон Унгерний түүх: Үнэнийг дахин сэргээсэн туршилт*, УБ, 2013, 269, 270, 441; Магсаржав Н. *Монгол улсын шинэ түүх*, Эмхтгэж хэвлэлд бэлтгэсэн Эмгэнт О.Батсайхан, Харнууд З.Лонжид, УБ, 2010, 216, 217.

⁵³ *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх*, СССР-ийн Шинжлэх Ухааны академи, БНМАУ-ын Шинжлэх Ухааны академи, УБ, 1955, 329, 330; *II дахь хэвлэл*, УБ, 1966, 318; *III хэвлэл*, УБ, 1984, 385.

суллажээ⁵⁴” хэмээн тэмдэглэсэн байдаг.

Тэрчлэн, МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын Түүхийн Институтаас гаргасан “Монгол Ардын Хувьсгалт Намын товч түүх” хэмээх номд,

“Ангийн дайсны анхны ноцтой эсэргүүцэл нь ардын хувьсгал ялсны дараахан саж лам Жамьянданзан тэргүүтэй этгээд Ардын засгийн эсрэг хуйвалдан тэрсэлсэн явдал байв. Богдын шадар харгис феодалууд хувьсгалаар онцгой эрх дархаа алдаж ардын засагтөшсөн төвдхудалдаачин, лам нарыг ашиглан ардын засгийг эсэргүүцэн босохоор бэлдэж байсан хуйвалдааныг 1921 оны намар илрүүлэн устгав⁵⁵”

гэж гурван янзын цаг хугацааг дурджээ. Саж лам нарыг 1921 оны 12 дугаар сарын 20-ны шөнө болон 12 дугаар сард баривчилсан гэдэг санал зарим талаараа судалгаа хангалтгүй, нотлох баримт дутмаг нөхцөлд Монголын түүхийг бичсэн Зөвлөлтийн түүхчдийн түүх бичлэгийн тусгал гэлтэй. Харин “1921 оны намар эсэргүү төвдүүдийг илрүүлэн устгасан” гэх бичлэг аман сурвалжид тулгуурласан шинжтэй байна.

Архивын эх сурвалжийг судлахад дээрх мэдээнүүд нотлогдсонгүй. Шүүх яамнаас гаргасан “Олнаа өргөгдсөний 11 дүгээр он (1921)-д гянданд хоригдогсдын бүртгэл” хэмээх давхардсан байдлаар 672 хүн бүртгэгдсэн баримтанд,

“№372. Саж лам Данзан, Амдоогийн харьяат, Олнаа өргөгдсөний 11 дүгээр оны 9 сарын 21-нд гянданд хорьсон⁵⁶” гэж тэмдэглэснээс гадна эл хэрэгт холбогдон байцаагдаж байсан төвөдүүд 9 сарын 21 (1921.10.22)-ний өглөө баривчлагдснаа бүгд өчсөнөөс⁵⁷ үзэхэд Саж лам тэргүүтэй төвөдүүдийг Олнаа өргөгдсөний 11 дүгээр он намрын сүүл сар (9 сар)-ын 21 буюу аргын 1921 оны 10 дугаар сарын 22⁵⁸-нд нэгэн зэрэг баривчилсан нь тодорхой байна.

Тэднийг Ардын засгийг устгахаар завдсан гэж буруутгаж байсан хандлагыг одоог хүртэл манай түүх бичлэгт баримталсаар байгаа боловч Монгол Улсын Үндэсний Төв Архивт хадгалагдаж байгаа дээрх хэрэгт баривчилагдсан төвөдүүдийн мэдүүлэг⁵⁹, холбогдох бусад баримтуудыг нягтлан судлахад үүнийг батлах баримт хараахан илэрсэнгүйгээр үл барам тэдний хэргийг эцэслэн шийдвэрлэлгүй гянданд хорьж хүлээлгэж байгаад тэргүүлэгч гэгдсэн Саж ламыг “Бодоогийн хэрэг” гэгчид нэр оруулж, огт өөр зүйлээр ялласан нь төвөдүүдэд холбогдох уг хэрэг зохиомол байсны илэрхийлэл болов уу.

⁵⁴ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх: Гутгаар боть, Нэн шинэ үе, БНМАУ-ын Шинжлэх Ухааны академи, Түүхийн хүрээлэн, УБ, 1969, 181.

⁵⁵ Монгол Ардын Хувьсгалт Намын товч түүх, Намын улс төрийн сургуульд зориулав, МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын Түүхийн Институт. I, II дахь хэвлэл, УБ, 1967, 1970, 80, 81.

⁵⁶ МУУТА. Х-284, Д-1, ХН-36.

⁵⁷ МУУТА. Х-284, Д-1, ХН-23.

⁵⁸ Сономдагва Ц. *Он тооллын хэлхээ. /1912-1930/, Эрдэм шинжилгээний өгүүлүүд*, Tomus VII, ШУА-ийн Түүхийн хүрээлэн, УБ, 1968.

⁵⁹ МУУТА. Х-284, Д-1, ХН-23.

3. Улсын баяраар явагдсан баривчилгаа

Саж ламыг шоронгийн хашаанд бариулсан хувийн гэртээ биеэ сувилуулан байхад хэсэг хүмүүс улс төрийн хэрэгт баригдсан чимээ гарсан нь Бодоо тэргүүтэн байв. Бодоо нарыг ямар шийдвэрээр хэзээ, хэрхэн баривчилсан тухай хууль эрхийн албан ёсны баримт Монгол Улсын Үндэсний Төв Архивын Орчин үеийн баримтын санд хадгалагдаж байгаа Ардын Засгийн Газар, Шүүх яам, Дотоод яамны хөмрөг, МАН-ын Баримтын төвд буй МАН-ын түүхэнд хамаарах баримтууд, “Бодоогийн хэрэг” гэгч нэрийн дор нэгтгэсэн байцаалтын тэмдэглэл болон Батлан Хамгаалахын Төв Архив, Гадаад Харилцааны Төв Архив, ТЕГ-ын Тусгай Архивын хамаарах баримтыг судлан нягтлахад илэрсэнгүй.

Марксист түүх бичлэгт Бодоо ба бусад хуйвалдагчдыг 1922 оны 8 дугаар сард баривчилсан талаар тэмдэглэж байсан⁶⁰ бол 1990 оноос хойш энэ хандлага өөрчлөгдөж, Бодоо нарыг 1922 оны 6 дугаар сард баривчилсан⁶¹ хэмээн бичих болжээ.

Гэвч, дээрх баривчилгааг 1922 оны 6 дугаар сард бус, 8 сард явуулсныг баримтууд нотолж байна. Үүнд, эдүгээ Үндэсний Төв Архивын МАН-ын Баримтын төвд хадгалагдаж байгаа “Бодоогийн хэрэг”-т холбогдогсдын мэдүүлгүүдээс цаг хугацааны хувьд хамгийн эхнийх нь сургагч Сорокины байцаан авсан Бодоогийн мэдүүлэг 1922 оны 8 дугаар сарын 5-ны өдрөөр огноологдсон⁶² байна.

Үүнээс үзэхэд дээрх хэрэгт холбогдогсдыг 1922 оны 8 дугаар сарын эхээр баривчилсан бололтой байна. Энэ таамаглалыг Японы түүхч Аоки Масахирогийн сүүл үеийн судалгааны үр дүнд илэрсэн мөрдөн байцаагч Сорокины 1922 оны наймдугаар сарын 29-ний өдрийн илтгэл баталж байна. ОХУ-ын Гадаад Хэргийн Яамны Архивт хадгалагдаж байгаа тэр баримтанд Бодоог мөнхүү 8 дугаар сарын 2-ноос 3-нд шилжих шөнө баривчилсан⁶³ талаар мэдээлжээ.

1922 оны 8 дугаар сарын 29-нд Зүүн Сибирийн цэргийн тойргийн Тусгай хэлтсийн даргад явуулсан ДХГ-ын сургагч А.Сорокины тэрхүү илтгэлд тэмдэглэснээс Бодоо нарыг баривчлах ажиллагааг хэрхэн зохион байгуулсныг дүрсэлбэл дараах байдлаар үйл явдал өрнөжээ.

Монгол дахь Зөвлөлтийн төлөөлөгч Охтин болон Кубаны 5 дугаар морьт цэргийн дарга Гильман хоёр Бүх Цэргийн Зөвлөлд Бодоо нарыг баривчлах

⁶⁰ *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх*, СССР-ийн Шинжлэх Ухааны академи, БНМАУ-ын Шинжлэх Ухааны академи, УБ, 1955, 329, 330; *Монгол Ардын Хувьсгалт Намын товч түүх*, Намын улс төрийн сургуульд зориулав, МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын Түүхийн Институт, I, II дахь хэвлэл, УБ, 1967, 1970, 80, 81.

⁶¹ *Монгол Ардын хувьсгалт намын түүхэн замнал*, Эрхэлсэн МАХН-ын Эрдэм шинжилгээ, сургалт, мэдээллийн төв, УБ, 1995. 39, 40; *Монгол Улсын түүх: Тавдугаар боть*, ШУА-ийн Түүхийн хүрээлэн, УБ, 2003, 146.

⁶² МАНБТ. ХЦ-6, Д-1, ХН-15, нуг 4.

⁶³ Аоки Масахиро. “Бодоогийн хэрэг” ба Гадаад Монголын улс төрийн байдал, *Shigaku zasshi*, 119-3, Токио, 2010, 16 (308); монгол орчуулга: *Түүхийн судлал*, Том XL, Fasc 16, ШУА-ийн Түүхийн хүрээлэн, УБ, 2010, 245.

талаар идэвхтэй зөвлөгөө өгч, Засгийн газрыг унагахаар хуйвалдсан гэх хүмүүсийг баривчлах шийдвэр ба баривчлагдах хүмүүсийн нэрсийн жагсаалтыг Охтины оролцоотойгоор гаргаж, баривчлагааны төлөвлөгөөг Бүх Цэргийн Зөвлөл баталсан аж⁶⁴. Тухайн үед гяндангаас оргох гэж байгаад баригдсан Богдын Их шавь, Бишрэлтийн дарга Цэндотгийн харьяат Дамбийжанцан хэмээх Санжаадамба Олнаа өргөгдсөний 12 дугаар он 6 сарын 19 (1922.08.11)-ний өдрийн мэдүүлэгтээ,

“гянданд хоригдон байхдаа 6 сарын 10-даар (1922.08.05-ны орчим) гэнэт хувьсгал өдүүлж оргох санаа төрөхөд хувьсгалын хэрэгт баригдсан Бодоо нарын зэрэг 40 гаруй хүмүүсийг гаргаж авахаар шавь болгосон банди Сандагдорж, Тавхай, Ёндон нарт хэлсний зэрэгцээ багш шавь бололцсон Цэен түүний хойно: Цэвээн тэргүүн, Бодоо, гүн Дэндэв, Тогтох, Дүйнхэрийн Да лам нар зөвлөж, Манжуур зүг явж гадаад улс ба цагаан нам лугаа нийлэхээр хэлэлцэж байгаад сая 40 гаруй хүмүүсийн хамтад баригдав хэмээсэн үг надад хэлсэн”⁶⁵

хэмээн өчжээ. Түүнчлэн Сайн ноён хан аймгийн сайд жанжин ван Жамъянгийн хошууны харьяат хар Сүхэндэйн Олнаа өргөгдсөний 12 дугаар он 6 сарын 19 (1922.08.11)-ний өдрийн өчигт,

“Гянданд хоригдон суутал, энэ 6 дугаар сарын 17 (1922.08.09)-ны өдөр гяндан дотор лам Сандагдорж гяндангаас оргох талаар хэлэхдээ, баригдсан Бодоо нарын 40 гаруй хүмүүсийг гаргаж тэдэнд засгийн эрхийг бариулна гэж өгүүлсэн”⁶⁶

байдаг. Мөн 1922 онд Засгийн газрын нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Г.Навааннамжил хожим “Өвгөн бичээчийн үгүүлэл” хэмээх дуртгалын номондоо,

“Бодоо ерөнхий сайдын тушаалаас огцрогдож, Богдод улам шадарлаж, даа лам Пунцагдорж, шадар сайд гэгдэх Чагдаржав, Дэндэв, гүн Тогтох нарын зэрэг хүмүүстэй нийлэлцэн, Япон улсыг түшиглэн, хувьсгалт нам засгийг устгаж, хаант засаг байгуулахаар нууц бүлгэм болж байсан хэрэг илэрч 1922 оны 7 дугаар сард шинэ байгуулагдсан Дотоодыг Хамгаалах Газарт баривчлагджээ”⁶⁷

гэж бичсэн нь тэднийг 1922 оны 6 дугаар сард баривчлаагүй, ДХГ газар байгуулагдсны дараа баривчлагдсныг илтгэнэ.

Бодоог баривчилсан аргын 1922 оны 8 дугаар сарын 2-ны өдөр билгийн улирлын 6 сар (зуны сүүл сар)-ын 10-ний өдөртэй дүйх бөгөөд энэ нь 1922 оны

⁶⁴ Мөн дээрх.

⁶⁵ МАНБТ, ХЦ-6, Д-1, ХН-16, 46-51.

⁶⁶ МАНБТ, ХЦ-6, Д-1, ХН-18, 10-13а.

⁶⁷ Навааннамжил Г. *Өвгөн бичээчийн үгүүлэл*, УБ, 1956, 257-259.

Улсын баярын дараах өдөртэй таарч байна.

1922 оны долдугаар сарын 25-ны өдрийн Засгийн газрын 32 дугаар хурлын нэгдүгээр зүйлд: Жил бүр явуулах Улсын баяр ёслол явуулах тухай дүрэм хэмжээг баталж⁶⁸, Улсын баярыг 3 хоног үйлдэж байхаар тогтоосны зэрэгцээ Засгийн газраас гаргасан 56 тоот тушаалаар,

“...Хатуу зоригоор гадаад лугаа эсэргүүцэн байлдаж, Олноо өргөгдсөний 11 дүгээр оны сүүл сар (зуны сүүл сар)-д харьяат газар орныг эзэрхсэн гадаадын дайсныг арилгаж Нийслэл Хүрээг бүрэн бүтнээр эзлэж аваад хуучны эрхт засгийг устгаж, мөн сарын зургааны өдөр Богд Жибзундамба хутагт хааныг хэвээр Монгол Улсын хаанд өргөмжлөн Ардын эрхт хэмжээт цаазат засгийг байгуулан зарлуулах элдэв хэргийг үүсгэж шийтгэх явдлыг арилгаж батлан тогтоосны тулд жил бүрийн зуны сүүл сарын шинийн зургааны өдрийг улсын баяр ёслолын өдөр болговоос зохих бөгөөд одоо энэхүү баярын өдөр учир нийтийн их баяр ёслолоор шавь сайдууд, олон лам, ноёд, цэргийн ихээхэн түшмэдүүд ёслон өнгөрүүлсүгэй”⁶⁹

хэмээн зарлажээ.

Цахилгаан мэдээний хорооноос 7 хоног тутамд 2 удаа гаргаж байсан “Хураангуй сэтгүүл” хэмээх бэсрэг сонинд нийтлэгдсэн баярын тухай мэдээнд,

“Монгол Ардын засгийн нэгэн жил болсны баяр ёслолыг аргын 7 сарын 30-ны өдрөөс эхлэн гурван өдөр дараалан цэнгэлдэн найралдсан бөгөөд анх өдөр Богд хааныг дотор ордноо залж баяр өргөвэй. Хоёрдугаар өдөр Гаалийн хорооны дэргэдэх их чөлөөн дээр нийтээр хуралдаж баяр үүсгээд үүний сүүлд Засгийн газар их ширээ бэлтгэж цэнгэлдэн найралдвай. Сүүлчийн өдөрт мөн их чөлөө дээр Монгол ардын олон морин цэргүүд орж, олон зүйлийн цэргийн сургуулиа илэрхийлж, жавхлант сүрийг дуурсгажухуй”⁷⁰

хэмээн бичсэн нь 1922 оны 8 дугаар сарын 2-ны өдрийг Улсын баярын маргаадар байсныг нотолно. 1922 оны зуны сүүл сар нь шинийн зургаангүй байсан тул Улсын баярыг шинийн 7-9-нд явуулсан нь тэр билээ.

Тийнхүү Улсын баярын маргааш зуны сүүл сарын 10-нд буюу 1922 оны 8 дугаар сарын 2-ны шөнө Бодоог баривчилсан нь Монгол Улсын төрийн тэргүүнүүдийг Улсын баяр наадмын үеэр болон Үндсэн хууль баталсан өдөр нь баривчилдаг, шийтгэдэг, цаазлан тохуурхдаг явдал Ардын Засгийн анхны

⁶⁸ Бат-Очир Ц. *Үндэсний бөх*, УБ, 1991, 20.

⁶⁹ Нямбуу Х. Манай оронд хувьсгалт шинэ баяр наадам үүссэн нь, *Түүхийн судлал*, Томус 15, УБ, 1975, 53, 54.

⁷⁰ *Хураангуй сэтгүүл*. 1922.08.26. №13, 14. Нүүр 1.

Ерөнхий сайд Бодоог хэлмэгдүүлэх үеэс эхэлснийг гэрчилнэ. Тодруулбал, 1937 оны наадмаар Ерөнхий сайдасан П.Гэндэнг Зөвлөлтийн Сочи дахь “Кавказская” зочид буудлаас тус улсын ДХАК-ын газрын ажилтнууд баривчилж⁷¹, мөн оны 11 дүгээр сарын 26-ны өдөр буюу Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг тунхаглан зарласан өдөр ЗХУ-ын нутаг дэвсгэр дэх Бутырын шоронд буудан хороосон⁷² бол 1939 оны наадмын үеэр Улсын Бага Хурлын дарга Д.Догсом, орлогч дарга Д.Лосол, Сангийн сайд С.Довчин, МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга Д.Лувсаншарав нарыг баривчилж, оросын газар нутаг дээр ЗХУ-ын Дотоод явдлын яамны сайд Ягодагийн зуслан, Москвагаас холгүй орших Бутово дахь буудлагын талбайд⁷³ 1941 оны наадмаар Ерөнхий сайд Амар нарын хамтаар буудан хороосон⁷⁴ юм.

Түргэний голд зусаж байсан⁷⁵ Бодоог Улсын баяр үзчихээд дөнгөж гэртээ хариад амарч хоносон шөнө нь тийнхүү барьсантай зэрэгцүүлэн шадар сайд асан Чагдаржав, Пунцагдорж, Дэндэв, Шүүх яамны дэд сайд асан Тогтох, Сангийн яамны сайд асан Лувсанцэвээн, түүний хамаатны чойжин хүүхэн Хандсүрэн, чойжин хүүхний нөхөр Аningаа, цэрэг Алтангэрэл, Чагдар, Гомбо, цахар Фэншэнгаа, Бодоогийн гэрт суух хөдөлмөрийн лам Мижид, Түшээт хан аймгийн Баатар ван Наваан-Юндэнгийн хошууны лам Ойдов, ард Лувсантунсаг нарын 15 хүнийг “Бодоогийн хэрэг”-т холбогдуулан баривчилсан нь Дамбийжанцан хэмээх Санжаадамба⁷⁶, хар Сүхэндэй⁷⁷ нарын дээрх өчгүүдээс мэдэгдэж байна.

4. “Бодоогийн хэрэг”-т холбогдогсдыг цаазласан цаг хугацааг тодруулах нь

Мөрдөн байцаалтад эрүү шүүлт хэрэглэхийг тухайн үеийн хууль цаазаар хүлээн зөвшөөрсөн байсан⁷⁸ учир “Бодоогийн хэрэг”-т мөрдөн байцаалтын өрнө, дорнын аргыг хослуулан хэрэглэж⁷⁹, эрүү шүүлтийг өргөн дэлгэр ашигласны улмаас уг хэрэгт нэр холбогдогсод улс төрийн хилс хэрэг хүлээжээ⁸⁰.

Харгис эрүү шүүлтэндаван улс төрийн хэрэгт хилс тулгагдсан Бодоо нарт 1922 оны 8 дугаар сарын 30-нд хуралдсан Засгийн газрын 38 дугаар хурлаас цаазын ял оноож, 24 цагийн дотор гүйцэтгэхээр тогтоожээ⁸¹.

⁷¹ Улс төрийн хэлмэгдэгсдийн намтрын товчоон, Боть XI, УТХХСТөв, УБ, 2008, 229.

⁷² Мөн дээрх, 237.

⁷³ Улс төрийн хэлмэгдэгсдийн намтрын товчоон, Боть XVIII, УТХХСТөв, УБ, 2013, 11, 12.

⁷⁴ Улс төрийн хэлмэгдэгсдийн намтрын товчоон, Боть XV, УТХХСТөв, УБ, 2012, 255.

⁷⁵ Бат-Очир Л. Догсомын Бодоо... , Д.Бодоогийн амьдрал үйл ажиллагааны талаар доктор, профессор Л.Бат-Очирын хийсэн судалгааны бүтээлийн эмхэтгэл ба Д.Бодоогийн бүтээлээс, УБ, 2010, 142.

⁷⁶ МАНБТ, ХЦ-6, Д-1, ХН-16, 46-51.

⁷⁷ МАНБТ, ХЦ-6, Д-1, ХН-18, 10-13а.

⁷⁸ МАНБТ, Х-12, Д-1, ХН-22, 43, 44; МАНБТ, Х-4, Д-1, ХН-42, 39, 40; МУУТА, Х-4, Д-1, ХН-12, 300; МАНБТ, Х-12, Д-1, ХН-33, 28-31.

⁷⁹ Зөвлөлтийн анд нөхөд Д.Сүхбаатарын тухай, Дуртгал, бичиг, захидал, УБ, 1980, 90, 91.

⁸⁰ МАНБТ, ХЦ-6, Д-1, ХН-17, 103, 104.

⁸¹ МУУТА, Х-1, Д-1, ХН-73, 89-91; Ардын засгаас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд, УБ, 1954, 136, 137; Бат-Очир Л. Догсомын Бодоо (1885-1922), УБ, 2001, 131, 132.

Чингээд тогтоол ёсоор Д.Бодоо нарыг 1922 оны наймдугаар сарын 31-нд цаазлахаар Бүх цэргийн тэргүүлэгч Элбэгдорж Ринчино, сайд жанжин Сүхбаатар, штабын дарга Хува нар гарын үсэг зуран шийдэж, улсын засгийг устгахыг зөвлөн явсан ба нуун дарагдуулсан хэрэгт шийтгэгдсэн нэр бүхий 15 хүнийг Шүүх Таслах Яам болон Цэргийн Яам хамтран нийлж, Шүүх Яамнаас түшмэл, Цэргийн Яамнаас цэрэг 15-ыг гаргаж, билгийн улирлын 7 сарын шинийн 9-ний өглөөний 5 цагт Нийслэл Хүрээний зүүн хойд зах Шар хад хэмээх газарт буудаж цаазаар хороосон⁸² байна. Өглөөний 5 цаг хэмээх нь 07 цаг 40 минутаас 09 цаг 40 минутын хооронд тохиох луу цаг юм. Тэгэхээр Бодоо нарын 15 хүнийг аргын 1922 оны наймдугаар сарын 31-ний өдрийн өглөө мандах нарнаар 7-9 цагт цаазлан хороосон гэж болохоор байна.

Гэтэл, цаазын ялыг гүйцэтгэсний дараа Дотоодыг Хамгаалах газрын нууц туршуулуудаас ирүүлсэн мэдээнд,

“Бодоо нарын талын эзэрхэг хүмүүсийн хэлэлцэх үг нь: Манай монгол үүний урьд аливаа алах хүнийг урьдаар бичиг зарлаж, олноор үзэж байсан. Эдүгээ яагаад нууцаар шөнө олонд мэдэгдэхгүй алсан буй хэмээх мэтээр муутган хэлж байсан. Дараагаар ардын намд дуртай хүмүүсийн хэлэлцэх нь: Эдний хэдэн хүмүүсийг өдөр шөнө алсны ялгаваргүй хэмээмүй. Гагцхүү Бодоо нарын тал харгис хүмүүс олон байгаад эднийг өдөр алах тухайд хувьсгал гаргах болуужин хэмээснээс ийнхүү шөнө алсан буй за хэмээн хэлэлцэж амуй⁸³”

гэж онцолсон нь хэрэг дээрээ Бодоо нарыг шөнийн цагаар цаазалсныг нотолж байна.

Харин албан баримтанд билгийн тооллын өглөөний 5 цаг (луу цаг) буюу аргын 8-9 цагт цаазалсан мэтээр тэмдэглэсэн нь шөнө дөлөөр нууцлан цаазласан явдлаа цайруулах гэснийх буй за.

Нөгөөтээгүүр, Бодоо нарыг 1922 оны наймдугаар сарын 31-нд буюу Олнаа өргөгдсөний 11 дүгээр оны намрын эхэн сарын 28-нд цаазалсан нь тухайн үед даган мөрдөж байсан алах ял гүйцэтгэх журамтай зөрчилдөж байна. 1920-иод оны дунд үе болтол тус улсын бүхий л хүрээний харилцааг зохицуулсаар байсан манжийн болон сэргэн мандсан Монгол улс (1911-1919 он)-ын үеийн хууль дүрмээр алах ял шийтгүүлсэн хэрэгтнийг тэр даруйд хороодоггүй, хар гэрт хорьж байгаад намрын сүүл сард цаазалдаг байсан гэдэг .

Ардын Засгийн газраас “Бодоогийн хэрэг” гэгчийг таслан шийтгэхдээ, манжийн үеийн, “Үгслээр урвасан ба нуун дарсан цаазны бичиг”-ийг мөрдөж, буудан алах ял оноосон атлаа шийдвэр гүйцэтгэх ажиллагааг холбогдох хуулийн дагууд намрын сүүл сард явуулалгүй, харин 24 цагийн дотор даруй буудан алахаар тогтоосон нь уг хэрэг улс төрийн зорилготой зохиомол хэрэг гэдгийг давхар гэрчилнэ.

⁸² МАНБТ, ХЦ-6, Д-1, ХН-17, 26.

⁸³ МАНБТ, Ц-6, Д-1, ХН-17, 13, 14.

Монголд улс төрийн хэлмэгдүүлэлт эхэлсэн цаг хугацааны тухайд

Тийнхүү Оросууд Богд хаан, Ардын Засгийн газрын Ерөнхий сайд, Сангийн сайд нарын зөрчлийг овжноор ашиглаж, зохион байгуулсан “Бодоогийн хэрэг” гэгчээ итгэл үнэмшилтэй болгохын тулд 1921 оны хувьсгалын ялалтын үеэр улс төрийн хэрэгт баривчлагдаад Богд хааны нөлөөгөөр хэрэг нь түдгэлзэн хүлээгдэж байсан Цэвээн тэргүүн, Саж лам нар төдийгүй Бодоо хэмээх нэрийг дуулснаас цаашгүй цэргийн албан хаагч, энгийн малчин ард гэх зэрэг жирийн хүмүүсийг хүртэл уг хэрэгт нэгтгэн яллаж, төрийн цаазаар хороожээ.

Үндсэндээ “Бодоогийн хэрэг” гэгчид хамаарагсад нь төрийн зүтгэлтнүүд, түшмэд, цэргүүд, энгийн ард, гадаадын харьяатгэсэн 5 бүлэгт хамаарч байснаас гадна хэргийн үндсэн бүрдэл нь Цагаантны талыг баримтлагчдын хэрэг, төвөдүүдийн хэрэг, Бодоо нарын улс төрийн хэрэг, Оргодлуудын бүлэг гэсэн 4 хэсэгтэй байв. Тэдний нийгмийн байдлыг Хүснэгт 2-оос үзнэ үү.

Хүснэгт 2.

Д/д	Нэрс	Нас	Харьяат нутаг	Алба тушаал	Хэзээ баривчлагдсан
1	Д.Бодоо	37	Их шавь	Ерөнхий сайд асан	1922.08 сар
2	Д.Чагдаржав	42	Их шавь	Шадар сайд асан	
3	С.Тогтох	43	Сайн ноён хан аймаг	Шүүх яамны дэд сайд асан	
4	Д.Пунцагдорж	45	Их шавь	Дотоод яамны сайд асан	
5	Ө.Дэндэв	41	Сэцэн хан аймаг	Шадар сайд асан	
6	Г.Лувсанцэвээн	53	Түшээт хан аймаг	Сангийн яамны сайд асан	1921.07.20-ны өдөр
7	Ж.Алтангэрэл	22	Их шавь	Цэрэг	1922.08 сар
8	Н.Гомбо	34	Сайн ноён хан аймаг		
9	Чагдар	28	Сэцэн хан аймаг		
10	Анингаа	59	Их шавь	Бичгийн түшмэл	1922.08 сар
11	Г.Санжаадамба	25	Их шавь	Лам	1922.07 сар
12	Д.Сүхэндэй	34	Сайн ноён хан аймаг	Энгийн ард	1922 оны хавар
13	Д.Дамба	38	Түшээт хан аймаг	Энгийн ард	1922 оны цагаан сар
14	Б.Цэен	38	Засагт хан аймаг	Энгийн ард	1922.07 сар

15	Жамъянданзан	41	Төвөдийн Амдоо муж	Саж лам	1921.10.22-ны өдөр
----	--------------	----	-----------------------	---------	-----------------------

Бодоо нарыг цаазалсны дараа гянданд үлдсэн Түеэ, Дондогжамц, Балданжамц, Лувсан, Данзан, Дагважамц нарын Амдоогийн төвөд 6 хүнийг⁸⁴ цэрэг дөрвөөр харгалзуулан зөвхөн өртөө улаа хэрэгсүүлж, Түшээт хан аймгийн Түшээт чин ван Лхамсүрэнгийн хошууны⁸⁵ нутгийн баруун өмнө зах хүргэж, мөнхүү хошуунаас уналга ачлагын тэмээ 7, хүнсний хонь 12, майхан тогоо, шанага, сэлтийг гаргуулан олгуулж, хязгаараас үлдэн гаргаж, дахин Монгол хязгаартүүрдоруулахгүй болгохоор шийдвэрлэж⁸⁶, 1922 оны 10 дугаар сард тус улсаас хөөн гаргажээ.

Дүгнэлт

Дээр дурдсан баримтуудаас үзэхэд, Монгол дахь улс төрийн хэлмэгдүүлэлтийн эхлэл нь 1921 оны 7 дугаар сарын 7-ноос 1922 оны 10 дугаар сарыг хүртэл жил гаруй хугацаанд дамнан үргэлжилсэн, эхлэл-өрнөл-төгсгөл хэсгүүдээс бүрдсэн цогц үйл явц байсан аж.

Энэ үйл явц нь 1921 оны 7 дугаар сарын 7-нд Тогтох тайжийг баривчилснаас эхлэн, “Цэвээн тэргүүний хэрэг”, “Саж ламын хэрэг”, “Бодоогийн хэрэг” гэгч олон зохиомол хэргээр өрнөж, 1922 оны 8 дугаар сарын 31-нд Бодоо нарын 15 хүнийг цаазалж, 1922 оны 10 дугаар сард улс төрд тэрсэлсэн гэх төвөдүүдийг тус улсаас хөөн гаргаснаар төгсгөл болжээ.

Тиймээс Монгол дахь улс төрийн хэлмэгдүүлэлтийг 1922 оны “Бодоогийн хэрэг” (1922 он)-ээс эхлүүлэн үзэж буй түүх бичлэгийн өнөөгийн хандлагыг эргэн нягтлууштай байна.

Хэдийгээр Богд хаантан Лувсанцэвээнд түр зуур гэрийн хорионд суулгах шийтгэл хүлээлгэж, амь биеийг нь авч үлдсэн, Саж лам тэргүүтэй төвөдүүдийг улс төрийн хэрэгт шийтгүүлэхээс түдгэлзүүлсэн боловч нэгэнт Зөвлөлтийн талынхны хараанд орчихсон тэднийг “Бодоогийн хэрэг” гэгчид чихэгдэн цаазлуулахаас хамгаалж чадаагүй билээ.

Эцэст тэмдэглэхэд, Монгол дахь улс төрийн хэлмэгдүүлэлт 1921 оноос 1990 он хүртэл бүтэн 70 жил үргэлжилжээ.

Abstract: Although the history of the Political Repression, a puzzling issue of the twentieth century Mongolian history, has been studied by historians, no investigation has been done in order to examine when and how the process of it began. Therefore, this brief study aimed to clarify the time the Political Repression started to take place in Mongolia. The study has come to the following conclusion. The beginning

⁸⁴ МУУТА, Х-284, Д-1, ХН-48, 174-177.

⁸⁵ Одоогийн Дундговь аймгийн өмнөд хагас, мөн Өмнөговь аймгийн зүүн талын нутаг дэвсгэрт тус хошуу оршин байв.

⁸⁶ МУУТА, Х-1, Д-1, ХН-73, 142-144.

process of the Repression was a composite event that continued in three phases consisting of the beginning, the development and the end between the 7th July of 1921 and the October of 1922. This event started with the arrest of Тогтогуу тайжи on the 7th July of 1921, followed by the fictitious cases including the Affair of the Тseven terigün, the Saji lama Affair and the Bodoо Affair in its development phase, and then by the execution of fifteen men including Bodoо on the 31st August of 1922 and the expulsion of Tibetans, who were accused of a plot against the state, from the country in the October of 1922 in its end phase. Therefore, it is necessary to re-examine the current trend in historiography in which the Bodoо Affair (1922) has been viewed as the beginning of the Political Repression in Mongolia.

Ном зүй

Нэг. Судалгааны зохиол

- Аоки Масахиро. “Бодоогийн хэрэг” ба Гадаад Монголын улс төрийн байдал. Токиогийн Их Сургуулийн “Түүхийн судлал” сэтгүүл. Токио., 2010. № 119 (3); МУ-ын ШУА-ийн Түүхийн Хүрээлэнгийн “Түүхийн судлал” сэтгүүл. УБ., 2010. Том XL, Fasc 16.
- Ардын засгаас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд., УБ., 1954.
- Бат-Очир Л. Анхны долоогийн нэг. “Намын амьдрал” сэтгүүл. УБ., 1989, № 7.
- Бат-Очир Л. Бодоо сайд: Үзэл ба үйлс. УБ., 1991.
- Бат-Очир Л. Бодоо сайд хэн байв. “Засгийн Газрын мэдээ” сонин. УБ., 1992. № 09 (22).
- Бат-Очир Л. Ерөнхий Сайд Бодоод хятадын харгис генерал Жан-Зо-Линтэй холбоо тогтоосон, Автономит Засгийг сэргээх гэсэн хэмээн ял тулгажээ. “Улаанбаатар таймс” сонин. УБ., 2001. № 75 (559).
- Бат-Очир Л. Догсомын Бодоо (1885-1922). УБ., 2001.
- Бат-Очир Л. Догсомын Бодоо... (Д.Бодоогийн амьдрал үйл ажиллагааны талаар доктор, профессор Л.Бат-Очирын хийсэн судалгааны бүтээлийн эмхэтгэл ба Д.Бодоогийн бүтээлээс). УБ., 2010.
- Бат-Очир Ц. “Үндэсний бөх”. УБ., 1991.
- Баярсайхан Б., Жанцан С., Энхнасан Ж., Сумъяацэрэн Д. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009). УБ., 2011.
- БНМАУ-ын Шинжлэх Ухааны академи, Түүхийн хүрээлэн. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх: Гутгаар боть (Нэн шинэ үе). УБ., 1969.
- Буруугүй буруутнууд. Зуун мод., 1993.
- Дамдинсүрэн Ц., Лувсандэндэв А. Орос-Монгол толь бичиг (Русско-Монгольский словарь). УБ., 1983.
- Гомбосүрэн Д. Зоригт баатар Э. Тогтох. УБ., 2003.

- Гомбосүрэн Д. Нийслэл Хүрээний цэргийн комендант ба Комендантын газрын үйл ажиллагаа (1921 оны долоодугаар сар). “Тусгаар тогтнол” сэтгүүл. УБ.,2012. №2.
- Зөвлөлтийн анднөхөд. Д.Сүхбаатарын тухай (Дуртгал,бичиг,захидал). УБ.,1980.
- Кузьмин С.Л. “Барон Унгерний түүх (Үнэнийг дахин сэргээсэн туршилт)”. УБ., 2013.
- Магсаржав Н. Монгол улсын шинэ түүх (Эмхтгэж хэвлэлд бэлтгэсэн Эмгэнт О.Батсайхан,Харнууд Э.Лонжид). УБ.,2010.
- МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын Түүхийн Институт. Монгол Ардын Хувьсгалт Намын товч түүх (Намын улс төрийн сургуульд зориулав) УБ.,1967.
- МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын Түүхийн Институт. Монгол Ардын Хувьсгалт Намын товч түүх (Намын улс төрийн сургуульд зориулав) [III дахь хэвлэл]. УБ.,1970.
- Монгол Ардын журамт цэргийн дуртгалууд (Боть II). УБ.,1986.
- Монгол Ардын хувьсгалт намын түүхэн замнал (Эрхэлсэн: МАХН-ын Эрдэм шинжилгээ,сургалт,мэдээллийн төв). УБ.,1995.
- Мөнхбаяр Х. Улс төрийн хэлмэгдүүлэлтийн үйл явц дахь Монголын тагнуулын байгууллагын оролцоо. “Аюулгүйн манаанд 90 жил” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ.,2012.
- Мөнхбаяр Х. Группийн хэрэг” ба Лхүмбийн байцаалт, эрүү шүүлтийн тухай нягтлах нь. “Лхүмбэ-110 жил” эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. УБ., 2012.
- Мөнхбаяр Х. Цэвээн тэргүүнээс Чимидийн Энхээ хүртэл. “Өнөөдөр” сонин (2012.09.25).
- МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Монголын төр,эрх зүйн түүхийн судалгааны төв. Монголын Төр,эрх зүйн түүх (Дээж бичиг: V дэвтэр): Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг. УБ.,2010.
- МУ-ын ШУА-ийн Түүхийн хүрээлэн. Монгол Улсын түүх (Тавдугаар боть). УБ.,2003.
- Навааннамжил Г. Өвгөн бичээчийн үгүүлэл. УБ.,1956.
- Нямбуу Х. “Манай оронд хувьсгалт шинэ баяр наадам үүссэн нь”. Түүхийн судлал. Томус 15. УБ.,1975.
- Сономдагва Ц. Он тооллын хэлхээ. /1912-1930/. ШУА-ийн Түүхийн Хүрээлэн. Эрдэм шинжилгээний өгүүллүүд (Томус VII). УБ.,1968.
- СССР-ийн Шинжлэх Ухааны академи,БНМАУ-ын Шинжлэх Ухааны академи. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх. УБ.,1955.
- СССР-ийн Шинжлэх Ухааны академи,БНМАУ-ын Шинжлэх Ухааны академи. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх. УБ.,1955. [II дахь хэвлэл] УБ.,1966.

- СССР-ийн Шинжлэх Ухааны академи, БНМАУ-ын Шинжлэх Ухааны академи. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх. УБ., 1955. [III хэвлэл] УБ., 1984.
- Урангуа Ж. ХХ зууны эхэн үеийн Монгол улс (1911-1919). УБ., 2010.
- УТХХСТӨв. Улс төрийн хэлмэгдэгсдийн намтрын товчоон (Боть XI). УБ., 2008.
- УТХХСТӨв. Улс төрийн хэлмэгдэгсдийн намтрын товчоон (Боть XV). УБ., 2012.
- УТХХСТӨв. Улс төрийн хэлмэгдэгсдийн намтрын товчоон (Боть XVIII). УБ., 2013.

Хоёр. Архивын эх сурвалж

- МУҮТА. X1, Д1, ХН 73.
- МУҮТА. X4, Д1, ХН 10.
- МУҮТА. X4, Д1, ХН 12.
- МУҮТА. X-284, Д1, ХН 1.
- МУҮТА. X284, Д1, ХН 5.
- МУҮТА. X284, Д1, ХН 7.
- МУҮТА. X284, Д1, ХН 8.
- МУҮТА. X284, Д1, ХН 21.
- МУҮТА. X284, Д1, ХН 23.
- МУҮТА. X284, Д1, ХН 24.
- МУҮТА. X284, Д1, ХН 36.
- МУҮТА. X284, Д1, ХН 48.
- МАНБТ. X4, Д1, ХН 42.
- МАНБТ. X12, Д1, ХН 22.
- МАНБТ. X12, Д1, ХН 23.
- МАНБТ. X12, Д1, ХН 33.
- МАНБТ. XЦ-6, Д1, ХН 15.
- МАНБТ. XЦ 6, Д1, ХН 16.
- МАНБТ. XЦ 6, Д1, ХН 17.
- МАНБТ. XЦ 6, Д1, ХН 18.

Гурав. Сонин хэвлэл

- “Хураангуй сэтгүүл” сонин. 1922.08.26. №13,14.

Дөрөв. Цахим эх сурвалж

- <http://www.legalinfo.mn/law/details/510?lawid=510> (Хууль зүйн яамны харьяа Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: Хандалтын огноо: 2014.09.10)